



ЗАХ ЗЭЭЛ

МАКРО ЭДИЙН ЗАСАГ | БАГАНУУР ХК | ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА | БОНДЫН МЭДЭЭ |
TOP 20 MSE ALL INDEX | КОМПАНИЙН БОНД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.01.29 - 02.02

АРИЛЖААНЫ ТОВЧ МЭДЭЭ

Өнгөрсөн 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 49 компанийн 530 сая төгрөгөөр 678,408 ширхэг хувьцаа нийт 1,000 удаагийн хэлцлээр арилжигдав.


“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 62.77%-иар буюу хамгийн ихээр өсч 105.80 төгрөгт хүрч хаагдсан бол “Түшиг уул” /TUS/ компанийн хувьцаа 13.28%-иар буурч 320 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн 1-р сарын 29-с 2-р сарын 2-ны хооронд ЗГҮЦ-ын анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн хувьд 4 удаагийн арилжаагаар 1,405 ширхэг үнэт цаас 142 сая төгрөгөөр арилжигдав.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр 4 ширхэг бонд 400,000 төгрөгөөр арилжигдсан байна.

2-р сарын 2-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,524 их наяд төгрөгт хүрсэн бол MSE ALL индекс 1,179 нэгж болж 0.07 %-иар өссөн байна.



/Сүүлийн 5 хоногийн байдлаар харуулав/ Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн
Арилжигдсан үнийн дүн	530,500,434
Зах зээлийн үнэлгээ	2,524,324,194,122

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,384	0.43% ▼
MSE ALL	1,179	0.07% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн
Апу	127,502	88,900,454
Говь	3,414	84,551,900
Таван толгой	6,677	70,296,040
Бидисек	29,660	35,509,269
Хөх ган	179,390	17,760,115

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Хөх ган	105.80	62.77% ▲
Мон наб	2,500	17.37% ▲
Хүннү менежмент	40.58	14.99% ▲
Оллоо	66	13.79% ▲
Хасу мандал	4,000	11.11% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Түшиг уул	320	13.28% ▼
Э-Транс ложистикс	92	12.38% ▼
Ногоон хөгжил ҮН	197.11	12.23% ▼
Нако түлш	110	8.33% ▼
Багануур	2,087	7.24% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Ширхэг	Үнийн дүн
Би Ди Сек ҮЦК	354,203	251,369,082
Бумбат алтай ҮЦК	119,115	89,680,785
Голомт капитал ҮЦК	191,655	82,893,767
Стандарт инвестмент ҮЦК	126,003	74,359,118
Ард капитал групп ҮЦК	41,472	43,456,482

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт	ЗЗҮ /сая.төг/
Апу	700.56	745,523
Таван толгой	10,320	543,504
МИК	11,450	237,121
Говь	24,860	193,935
Сүү	255.42	87,864

ӨНГӨРСӨН 7 ХОНОГИЙН ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
---	-----------------	--------------------	-----------	-----	---------	-------

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
1	Z GEB-BD-08/02/19-A0106-15	610	64,068,300	105,030	39	13,524%
2	Z GEB-BL-11/04/19-A0230-18	93	9,502,740	102,180	104	13,955%
3	Z GEB-BD-26/09/19-A0326-13	10	998,800	99,880	156	18,000%
4	Z GEB-BD-20/03/18-A0221-0	692	68,196,600	98,550	156	18,000%

ӨНГӨРСӨН 7 ХОНОГИЙН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА / ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ /

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
---	-----------------	--------------------	-----------	-----	---------	-------

1	SUUB-BD-29/06/18-C0006-17	2	200,000	100,000		17,500%
---	---------------------------	---	---------	---------	--	---------

Үнэт цаас гаргагчийн нэр:

Үнэт цаас гаргах зорилго:

Үнэт цаасны санал болгох хүрээ:

Үнэт цаасны төрөл:

Нэрлэсэн үнэ:

Хямдруулсан үнэ:

Нийт гаргах тоо:

Хүүгийн хувь хэмжээ:

Монгол улсын Сангийн яам

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлага

Олон нийтэд санал болгох

Засгийн газрын энгийн үнэт цаас

100,000 төгрөг

Энэ 7 хоногт ЗГҮЦ анхдагч зах зээлд арилжаалагдахгүй.

Долоо хоног бүр арилжигдах Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээг зах зээлийн жишиг хүүг үндэслэн Сангийн яам тогтооно.

Захиалга хүлээн авах хугацаа:

Лхагва гарагаас Мягмар гарагийн 11:30 цаг хүртэл



ШАРЫН ГОЛ ХК: 2017 ОНД 912 МЯНГАН ТОНН НҮҮРС ОЛБОРЛОСОН

"Шарын гол" хувьцаат компани 2017 онд сүүлийн 14 жилийн дээд хэмжээ буюу 912 мянган тонн нүүрс олборлосон талаар мэдээлсэн. 800 мянган тонн нүүрс олборлох төлөвлөгөөтэй байсан тус компанийн хувьд "Уулын баяжуулах эрдэнэт" үйлдвэрийн станцын өргөтгөл ашиглалтад орсон нь нийлүүлэлт өсөхөд нөлөөлсөн байна. Мөн 2017 оны эхний 11 сарын байдлаар 1.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, алт олборлолтын хэмжээ 120 кг хүрчээ. "Шарын гол" компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржээр дамжин олон нийтэд арилжаалагддаг. 2017 онд нийт 500 гаруй сая төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өнгөрсөн 2016 онтой харьцуулахад 10 дахин өндөр дүн болсон байна. "Шарын гол" компани олон нийтэд 10.2 сая ширхэг хувьцаа санал болгосноос өнгөрсөн онд 2.8 хувь нь эргэлтэд оржээ. Борлуулалтын хэмжээ төлөвлөгөөнөөс өндөр гарсан 2017 онд компанийн хувьцааны ханш 15 гаруй хувиар өссөн. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 31 тэрбум төгрөг даваад байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

АРИР: МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ "ТОДОРХОЙГҮЙ БАЙДЛААС" ГАРЧ ЧАДЛАА

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 онд дөрвөн хувиар тэлсэн гэж Азийн хөгжлийн банк таамаглаж байгаа юм. Өнгөрсөн оны эхэн үед тодорхойгүй байдал давамгайлж байсан бол одоо эдийн засаг хурдацтай сэргэж байгаа гэж ОУВС дүгнэсэн. Нүүрсний борлуулалт 120 хувиар өсөж, үйлдвэрлэлийн гарц 34 хувиар нэмэгдсэн, гадаад валютын нөөц 3.2 тэрбум ам.долларт хүрсэн зэрэг олон таатай дүн гарсан болохыг "Asia Pacific Investment Partners"-ийн шинжээч онцолж байна. 2018 оны тухайд гол төсөл болох Оюутолгойн үйл ажиллагааны зардлыг 2.8 дахин бууруулах боловч бүтээгдэхүүний гарцыг хоёр дахин нэмнэ гэж "Turquoise Hill Resources" мэдээлсэн. Цахилгаанжуулалт, автоматжуулалтыг нэмэгдүүлэх замаар төслийн үр ашгийг сайжруулах боломжтой гэж "Asia Pacific Investment Partners" харж байна. Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд хурдацтай сэргэсэн. Top-20 компанийн үнэлгээ 2017 онд 63 хувиар өсөж, Монголын хөрөнгийн бирж нийт 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь 26 жилийн түүхэн дэх анхны тохиолдол болсон.

2018 онд компаниуд шинээр IPO гаргахаар төлөвлөж байгаа юм. ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн нь ийнхүү хөрөнгийн зах зээлд ч эергээр нөлөөлсөн. Гэхдээ Засгийн газар бүтцийн шинэчлэл хийхгүй бол энэ байдал түр зуурынх болж магадгүй гэж "Asia Pacific Investment Partners" харж байна. Энэ мэтчилэн олон хүчин зүйлээс хамаарч Монголын эдийн засаг 2011 оных шиг хурдацтай тэлээгүй ч 2016 оны хямралтай харьцуулахад тогтворжиж байгаа гэж үзсэн байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

ALIBABA, FOXCONN: ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ ХӨГЖҮҮЛЭЛТЭД 350 САЯ АМ.ДОЛЛАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛНА

БНХАУ-ын цахим худалдааны "Alibaba" болон Тайванийн технологийн "Foxconn" компаниуд хамтран автомашин үйлдвэрлэгч "Xiaopeng Motors"-ийн цахилгаан автомашины хөгжүүлэлтэд 350

сая ам долларын хөрөнгө оруулахаар болжээ. "Xiaopeng" нь Хятадын зах зээлд хүч түрэн гарч ирж байгаа цахилгаан автомашин үйлдвэрлэгч старт-ап компаниудын нэг юм. XII сард "Alibaba", "GGV Capital" болон "Matric partners china" нар хамтран "Xiaopeng"-ийн анхны А цуврал автомашины санхүүжилтийг хийж байжээ. "Xiaopeng" энэ онд анхны "G3" загварын автомашинаа худалдаанд гаргах юм байна.

Эх сурвалж: Монцамэ агентлаг

"БАГАНУУР" ХК: 2017 ОНД ДӨРВӨН САЯ ТОНН НҮҮРС БОРЛУУЛЖ, 126.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГОТ ОЙ АЖИЛЛАСАН

Бямба гарагт Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн нар орон нутагт ажиллаж, Дулааны цахилгаан станцуудын нүүрсний хэрэгцээг хангадаг Шивээ-Овоо, Багануур ХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр Шивээ-Овоо, Багануур ХК-ууд үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, биелэлтийг танилцуулж, тулгамдаж буй асуудлуудынхаа талаар зөвлөлдөж ярилцсан байна. Компаниуд уурхайн хөрс хуулалт хоцрогдсон болон техникийн шинэчлэл хийх шаардлага тулгарсан нь гол асуудал болж байгааг мэдээлэв. "Багануур" ХК-ийн хувьд дотоодын нүүрсний хэрэглээний 50 хувь, төвийн бүсийн хэрэглээний 60 хувийг дангаараа хангаж байна. Гол асуудал нь өр төлбөрийн асуудал, мөн эрчим хүчний хэрэглээ өсөж байгаагаар холбоотой хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгааг онцолсон юм. Орд газрын хувьд нийт 812 сая тонн нүүрсний нөөцтэй. Багануурын нүүрсний уурхай 2017 онд дөрвөн сая гаруй тонн нүүрс олборлон борлуулж, 126.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Ингэснээр орлого нь өмнөх



2018 онд 19.1 сая метр куб хөрс хуулж, 4.1 сая тонн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн байна. Хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тухайд Багануур дүүрэгт 700 мВт-ын цахилгаан станцыг хоёр үе шаттайгаар 2020, 2024 онд барьж ашиглалтад оруулах, 2019 онд Дулааны III цахилгаан станцын 250 мВт өргөтгөл хийх, 2020 онд Дулааны II цахилгаан станцад 170 мВт-ын өргөтгөл хийх төлөвлөгөөтэй уялдан Багануурын уурхайн хүчин чадлыг 2019 онд 4.9 сая тонн, 2020 онд 6.7 сая тоннд хүргэх шаардлага гарч байгаа аж. Үүнээс үүдэн 2018-2022 онд 353 тэрбум төгрөгийн өртөг бүхий тоног, төхөөрөмж худалдан авч шинэчлэл хийх шаардлагатай байна гэж тус компанийн зүгээс мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.